



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн хорооны 1997 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 294 дүгээр тогтоолоор Нэгдсэн үндэстний гудамж дахь Бүгд Найрамдах Куба Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Монголын урлагийн ажилтны холбоо болон Монгол дахь Олон улсын хүүхдийн байгууллага ЮНИСЕФ-ийн байрлаж байсан барилгыг Гадаад харилцааны яамны дэргэдэх Дипломат байгууллагуудын үйлчилгээ, аж ахуйн газарт эзэмшүүлэхээр шийдвэрлэснийг Төрийн өмчийн хорооны 2001 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 500 дугаар тогтоолоор хүчингүй болгож шийдвэрлэхдээ “Монголын урлагийн ажилтны холбооны эзэмшиж байгаа барилга нь тус холбооны өмч болох нь нотлогдож байна” гэж үндэслэлгүй дүгнэлт гаргаж, төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн бус этгээдэд хууль бусаар шилжүүлсэн байх тул Төрийн өмчийн хорооны 2001 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 500 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороонд байрлах Нэгдсэн үндэстний гудамжны 18-р байр /хуучнаар Бүгд Найрамдах Куб Улсын Элчин сайдын яам байрлаж байсан байр/-ыг “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын эзэмшилд хэвээр үлдээсүгэй.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс /Ц.Түвшинзаяа/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  К.АРИУНБОЛД



0000273